

**АЙМГИЙН СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫН
ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР (2014-2018)**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Угсаатны бүлгүүдийн зан заншил, түүх соёлыг дэлхий нийтэд сурталчлах, хадгалах, хамгаалах, хөгжүүлэх, давтагдашгүй чанарыг баталгаажуулах, нийтийн биеийн тамир, спортыг хүн амын амьдралын хэв маяг, эрүүл аж төрөх ёс, амьдралын чанарыг дээшлүүлэх хэрэглүүр болгох, тамирчдын амжилтыг улс, тив, дэлхийн түвшинд хүргэхэд дэмжлэг үзүүлэх, байгаль, түүх соёлын дурсгалт газар, ахуйн соёлд түшиглэн олон улсын жишигт нийцсэн аялал жуулчлалын бүс болгох, аймгийн эдийн засагт гүйцэтгэх үүрэг, эзлэх байр суурь, үр ашгийг нэмэгдүүлэх, мэргэжилтэй боловсон хүчнээр хангах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, материаллаг баазыг бэхжүүлэн гадаад харилцааг өргөжүүлэх нь Соёл, спорт, аялал жуулчлалын салбарын гол зорилт болж байна.

Монгол Улсын Шинэчлэлийн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, “Монгол хөөмий”, “Монгол цуур”, “Уламжлалт бий биелгээ”, “Морин хуур, уртын дуу”, “Монгол тууль”, “Түүх соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах”, “Сонгодог урлаг-II”, “Биеийн тамир, спортыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-үүд, аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрүүд нь энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрх зүйн үндэслэл болно.

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

Соёл, спорт, аялал жуулчлалын салбарын үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх, нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх, Монгол Алтайн бүс нутгийн угсаатны бүлгүүдийн түүх, соёлыг өвлүүлэх, хадгалах, хамгаалах, судлах, сурталчлах, нийтэд түгээн дэлгэрүүлэх, үндэсний бахархлыг сэргээхэд хөтөлбөрийн зорилго оршино.

ГУРАВ. БАРИМТЛАХ ЗАРЧИМ

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална.

3.1.Хөтөлбөр нь соёл, спорт, аялал жуулчлалын хөгжлийн түвшин, эрэлт хэрэгцээ, сонирхол, боломж, итгэл үнэмшилд тулгуурлах;

3.2.Соёл, спорт, аялал жуулчлалын тухай хууль болон холбогдох бусад бодлогын баримт бичиг, хөтөлбөртэй нийцсэн байх;

3.3.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь нээлттэй, хүртээмжтэй, уян хатан, чанартай, шударга, тэгш байдлыг хангасан байх;

3.4.Хөтөлбөр нь олон улсын хөгжлийн чиг хандлага, үндэсний болон орон нутгийн онцлогт нийцсэн байх;

3.5.Төрийн болон төрийн бус байгууллага, иргэний нийгмийн оролцоо, иргэд гадаадын хандивлагч, сонирхогч бүх талын дэмжлэгт түшиглэх;

3.6.Мэдээлэл, харилцааны технологийн ололт амжилтыг ашиглах.

ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТУУД

4.1.1. Монгол Алтайн бүс нутгийн угсаатны бүлгүүдийн түүх, соёлыг өвлүүлэх, хадгалах, хамгаалах, судлах, сурталчлахад олон нийтийн оролцоог идэвхижүүлж, үндэсний бахархлыг сэргээн хөгжүүлэх;

4.1.2. Байгаль, түүх соёлын дурсгалт газар, угсаатны өв соёлд түшиглэн олон улсын жишигт нийцсэн аялал жуулчлалын бүс болгох, аймгийн нийгэм, эдийн засагт гүйцэтгэх үүрэг, эзлэх байр суурь, үр ашгийг нэмэгдүүлэх;

4.1.3. Нийтийн биеийн тамир, спортыг хүн амын амьдралын хэв маяг, эрүүл аж төрөх ёсны салшгүй хэсэг болгох, тамирчдын амжилтыг улс, тив, дэлхийн түвшинд хүргэхэд дэмжлэг үзүүлэх;

4.1.4. Соёл, спорт, аялал жуулчлалын салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, ашиглалт, үр өгөөжийг дээшлүүлэх;

4.1.5. Соёл, спорт, аялал жуулчлалын салбарын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, мэргэжилтэй боловсон хүчнээр хангах, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, ажилтан албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлүүлэх,

4.1.6. Соёл, спорт, аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэхэд төр, иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоог нэмэгдүүлж гадаад харилцааг хөгжүүлэх.

ТАВ. ХАМРАХ ХҮРЭЭ

Ховд аймгийн нутаг дэвсгэр, нийт иргэд.

ЗУРГАА. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА

Хөтөлбөрийг 2014-2018 онд хэрэгжүүлнэ.

ДОЛОО. ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

7.1. Зорилт 1-ийн хүрээнд дараах үйл ажиллагааг зохион байгуулна.

7.1.1. Монгол Алтайн бүс нутгийн түүх соёлын өвийг судлах, сэргээн засварлах, бэхжүүлэх улсын үйлдвэрийн газрыг музейг түшиглэн байгуулах;

7.1.2. Соёлын биет бус өвийг хамгаалах бүсийн төв байгуулах;

7.1.3. Соёлын биет болон биет бус өвийн цахим бүртгэл мэдээллийн сангийн үйл ажиллагааг өргөжүүлэх;

7.1.4. Соёлын үнэт зүйлийг бүтээгч, өвлөн уламжлагчийн өвөрмөц дэг жаягийг өвлүүлэх шавь сургалтыг зохион байгуулах;

7.1.5. Угсаатны бүлгүүдийн түүх соёлын өвийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн байгууллага ЮНЕСКО-гийн Дэлхийн өвийн жагсаалтад бүртгүүлэх ажлыг өргөжүүлэх;

7.1.6. Соёлын өвийгулс, орон нутгийн бүртгэл, хамгаалалтанд оруулах ажлыг өргөжүүлж, өв соёлын уралдаан наадмыг төрөлжүүлэн зохион байгуулах;

7.1.7. “Өв соёлын хүрээлэн”-гийн үйл ажиллагааг өргөтгөх, угсаатны соёл судалгааны төв болгох;

7.1.8. Соёл, урлагийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллага, дэмжигч аж ахуй нэгж, иргэдийг урамшуулах журам гаргах;

7.1.9. Ховд аймгийн нутаг дэвсгэр дээр хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг үйл ажиллагаанд зориулан газар олгоход түүх, археологи, палеонтологийн мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж хэвшүүлэх;

7.1.10 Угийн бичиг хөтлөх үйл ажиллагааг өргөжүүлэх;

7.2. Зорилт 2-ын хүрээнд дараах үйл ажиллагааг зохион байгуулна.

7.2.1. Аялал жуулчлалын бие даасан цахим хуудас нээх;

7.2.2. Аялал жуулчлалын эвент арга хэмжээнүүд, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, аялалын маршрут, үйлчилгээний байгууллагууд, хоноглох, отоглох

газруудыг багтаасан гарын авлага, газрын зураг, сурталчилгааны материалуудыг гаргах;

7.2.3. Аялал жуулчлалын эвент арга хэмжээнүүдийн тоог нэмэгдүүлэх, хугацааг тодорхой болгох;

7.2.4. Аялал жуулчлалын байгууллагуудын үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, мэргэжилтэй боловсон хүчний нөөцийг нэмэгдүүлэн, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалт, уралдаан тэмцээнийг зохион байгуулах;

7.2.5. Нутгийн иргэдэд тулгуурласан аялал жуулчлалыг хөгжүүлэх;

7.3.Зорилт 3-ын хүрээнд дараах үйл ажиллагааг зохион байгуулна.

7.3.1. Иргэдийн биеийн тамир, дасгал, хөдөлгөөнөөр хичээллэх явдлыг эрчимжүүлж, орчин нөхцлийг сайжруулах, олон нийтийн оролцоог идэвхжүүлэх;

7.3.2. Хүн амын эрүүл мэнд, бие бялдрыг хөгжүүлж, нийтийн биеийн тамирын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг дэмжин, чийрэгжилтийн түвшинг тогтоох сорилд иргэдийг хамруулах;

7.3.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэх үйл ажиллагааг идэвхжүүлэх;

7.3.4. Спортын холбоо, клубыг дэмжиж, шилдэг тамирчдын залгамж халаа бэлтгэх шаталсан тогтолцоог боловсронгуй болгох;

7.3.5. Спортын сонгосон төрлүүдээр тамирчдыг байнгын бэлтгэл сургуулилтанд хамруулж, олон улсын жишигт хүргэх;

7.3.6. Спортын төрлүүдээр онцгой амжилт гаргасан багш, дасгалжуулагч, тамирчдыг урамшуулан алдаршуулах журмыг мөрдүүлэх.

7.4.Зорилт 4-ын хүрээнд дараах үйл ажиллагааг зохион байгуулна.

7.4.1. Музей, Хөгжимт драмын театрын барилгыг шинээр барьж, нийтийн номын сангийн өргөтгөлийн барилгыг ашиглалтанд оруулах;

7.4.2. Соёл урлагийн байгууллагын хөгжим, техник хэрэгслийн хангалтыг үе шаттайгаар шинэчлэх;

7.4.3. Дөргөн, Буянт, Үенч сумдын соёлын төвийн барилгыг шинээр барих;

7.4.4. Булган, Дарви, Дуут, Ховд сумдын соёлын төвийн барилгуудад засвар хийх;

7.4.5. Спортын ордны барилга, Төв цэнгэлдэх хүрээлэнгийн барилга, байгууламжийг шинэчлэн засварлах;

7.4.6. Соёл, спорт, аялал жуулчлалын салбарын авто машины парк шинэчлэлийн асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх;

7.4.7. Нүүдлийн театр байгуулж, ашиглалтыг сайжруулах;

7.4.8. Стандартын шаардлага хангасан хөлбөмбөг, тэшүүрийн талбайг байгуулах;

7.4.9. Цахим номын санг байгуулж, техник тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх;

7.4.10. Соёл, спорт, аялал жуулчлалын газар, үндэсний спортын ордон, Жудо бөхийн ордны барилгуудыг шинээр барих;

7.4.11. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан номын сангийн танхим байгуулах.

7.5. Зорилт 5-ын хүрээнд дараах үйл ажиллагааг зохион байгуулна.

7.5.1. Соёл, спорт, аялал жуулчлалын салбарын мэргэжилтэй боловсон хүчний нөөцийг нэмэгдүүлж, чадавхжуулах сургалтыг үе шаттай зохион байгуулах

7.5.2. Соёл урлагийн их сургуулийн харъяа лицей сургуулийг байгуулах

7.5.3. Биеийн тамирын сургалттай дунд сургуулийг байгуулах

7.5.4. Соёл, спорт, аялал жуулчлалын салбарын ажилтан албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлүүлэх

7.5.5. Соёлын төвүүдийн үйл ажиллагааг тухайн орон нутгийн өв соёлын онцлогт тулгуурлан хөгжүүлэх

7.5.6. Олон угсаатны дуу бүжгийн чуулга байгуулах

7.6. Зорилт 6-ын хүрээнд дараах үйл ажиллагааг зохион байгуулна.

7.6.1. Төр, иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшлийнхний түншлэлийг хөгжүүлэх

7.6.2. Гадаадын улс орнуудтай хамтран ажиллах гэрээ байгуулж, олон улсын чанартай соёл урлаг, спорт, аялал жуулчлалын наадам, уралдаан тэмцээнийг зохион байгуулах, оролцох

НАЙМ.ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖИЛТИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

8.1 .Хөтөлбөрийг дараах байдлаар зохион байгуулна.

8.1.1. Хөтөлбөрийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах бодлого, эрх зүйн орчин бүрдүүлэх, төр, иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоо уялдаа холбоог хангах, хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилтийн хяналт–

шинжилгээ, үнэлгээ хийх, санхүүжилтийг шийдвэрлүүлэх асуудлыг Соёл, спорт, аялал жуулчлалын газар хариуцна.

8.1.2. Хөтөлбөрийн үйл ажиллагааны хэрэгжилтийн мониторингийн судалгааг Соёл, спорт аялал жуулчлалын газар, иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшлийнхний төлөөлөл, орон тооны бус арга зүйн зөвлөл хамтран хэрэгжүүлнэ.

8.1.3. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих үйл ажиллагааны чиглэл, зохион байгуулах сургалт, сурталчилгааны ажлын агуулга, арга зүй, санхүү, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг Засгийн газар, ССАЖЯ, аймаг, орон нутгийн удирдлага, соёл, спорт, аялал жуулчлалын салбарын байгууллагууд, иргэний нийгмийн байгууллага, төсөл хөтөлбөрийн байгууллага хамтран зохион байгуулна.

ЕС. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ШАЛГУУР

Хөтөлбөрийн хэрэгжилтийг төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хүрэх үр дүн болон шалгуур үзүүлэлтээр тооцно.

№	Үйл ажиллагаа	2013	2014	2015	2016	2017	2018
Зорилт 4.1 хүрээний шалгуур үзүүлэлт							
1	Монгол Алтайн бүс нутгийн түүх соёлын өвийг судлах, сэргээн засварлах, бэхжүүлэх улсын үйлдвэрийн газрыг музейг түшиглэн байгуулах.	-	-	-	+	+	+
2	Соёлын биет бус өвийг хамгаалах бүсийн төв байгуулах	-	-	-	+	+	+
3	Билиг авьяастны улсын бүртгэлд орсон өвлөн уламжлагчийн тоо	14	15	16	18	19	20
4	Аймгийн цахим бүртгэл мэдээллийн санд орсон биет бус өвийг өвлөн уламжлагчийн тоо	40	100	180	250	300	350
5	Цахим бүртгэл мэдээллийн санд орсон биет өвийн тоо	160	180	230	260	300	350
6	Соёлын үнэт зүйлийг бүтээгч, өвлөн уламжлагчийн өвөрмөц дэг жаягийг өвлүүлэх шавь сургалтын тоо	30	35	40	45	50	55
7	Шавь сургалтанд хамрагдагсдын тоо	2.500	3.000	3.500	4.000	4.500	5.000
8	Улсын хамгаалалтанд	9	10	11	12	14	15

	оруулсан түүх, соёлын дурсгалт газрын тоо						
9	Аймгийн хамгаалалтанд оруулсан түүх, соёлын дурсгалт газрын тоо	8	10	12	14	16	18
10	Угийн бичиг хөтөлсөн нийт өрхийн хувь	10	30	40	50	60	80
11	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан номын сангийн танхим байгуулах	-	+	+	+	+	+
Зорилт 4.2 хүрээний шалгуур үзүүлэлт							
12	Аялал жуулчлалын эвент арга хэмжээнүүдийн тоо	4	4	4	5	5	6
13	Аялал жуулчлалын байгууллагуудын мэргэжилтэй боловсон хүчний хангалтын хувь	30	40	50	60	70	90
14	Гадаад жуулчдын тоо	1.600	2.000	2.000	3.000	4.000	5.000
15	Дотоод жуулчдын тоо	10.000	11.000	12.000	13.000	14.000	15.000
Зорилт 4.3 хүрээний шалгуур үзүүлэлт							
16	Нийтийн биеийн тамираар хичлээллэдэг нийт иргэдийн тоо	6.500	7.000	7.500	8.000	9.000	10.000
17	Спортын секц дугуйланд хамрагдсан иргэдийн тоо	6.870	7.000	7.500	8.000	9.000	10.000
18	Идэвхитэй үйл ажиллагаа явуулж байгаа спортын холбоодын тоо	7	8	9	12	14	15
19	Олон улс, улс, бүсийн тэмцээн уралдаанаас авсан медалийн тоо	256	260	270	280	290	300
20	Хүн амын бие бялдрынчирэгжилтийн түвшинг тогтоох сорилд хамрагдсан иргэдийн тоо	4.103	5.000	6.000	7.000	9.000	10.000
21	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэгчдийн тоо	33	40	50	55	60	70
Зорилт 4.4 хүрээний шалгуур үзүүлэлт							
22	Соёл, спорт, аялал жуулчлалын салбарын шинээр баригдсан барилгын тоо	-	1	2	3	2	8
23	Засвар хийсэн барилгын тоо	1	1	1	1		4
24	Соёл, спорт, аялал жуулчлалын салбарын авто машины парк шинэчлэл хийгдсэн байгууллагын тоо	3	1	3	3	5	15

25	Стандартын шаардлага хангасан хөлбөмбөг, тэшүүрийн талбайг байгуулах	-			+	+	+
26	Цахим номын санг байгуулж, техник тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх	-		+	+	+	+
Зорилт 4.5 хүрээний шалгуур үзүүлэлт							
27	Соёл урлагийн байгууллагын мэргэжилтэй боловсон хүчний хангалтын хувь	54,6	60	65	70	80	90
28	Соёл урлагийн байгууллагаар үйлчлүүлсэн нийт иргэдийн тоо	249.855	250.000	258.000	280.000	310.000	350.000
29	Соёл урлагийн арга хэмжээний тоо	1.802	1.910	2.000	2.080	2.110	2.200
30	Шинээр болон сэргээн тавьсан уран бүтээлийн тоо	6	7	8	9	10	10
31	Музей, орон нутаг судлах танхимын үзмэрийн тоо	4.610	4800	5000	5300	5650	6.000
32	Аймгийн номын сангуудын фондонд байгаа нийт номын тоо	174.650	175.500	176.500	177.000	177.500	180.000
33	Нийтийн биеийн тамир спортын чиглэлээр зохион байгуулсан уралдаан тэмцээний тоо	86	88	90	95	98	100
34	Уралдаан тэмцээнд хамрагдсан иргэдийн тоо	500	550	600	650	700	800
35	Соёл урлагийн их сургуулийн харъяа лицей сургуулийг байгуулна	-	-	-	+	+	+
36	Биеийн тамирын сургалттай дунд сургуулийг байгуулна	-	-	-	+	+	+
37	Олон угсаатны дуу бүжгийн чуулга байгуулна	-	-	-	+	+	+
Зорилт 4.6 хүрээний шалгуур үзүүлэлт							
38	Иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшлийн хамтарч хийсэн ажлын тоо	30	33	38	43	46	50
39	Салбарын байгууллагуудын гадаадын улс орнуудтай хамтран хэрэгжүүлсэн ажлын тоо	2	2	3	4	4	5

АРВАН НЭГ. ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ

Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараахь эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

- Улсын төсөв
- Орон нутгийн хөгжлийн сан
- Хандивлагч орон, олон улсын байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн санаачилгаар хуримтлуулсан хөрөнгө, зээл, тусламж, хандив
- Бусад эх үүсвэр

----- оОо -----